



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 401

Арвайхээр

Гамшгаас хамгаалах албаны удирдлага штаб,  
мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг томилох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйл 34.2.3, 34.2.4, Татварын ерөнхий хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 27<sup>1</sup>.6.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах үүрэг бүхий гамшгаас хамгаалах албаны орон тооны бус удирдлага штабын бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Штабын дарга: Захиргаа, хуулийн тасгийн дарга газрын дарга

Үйл ажиллагааны тогтвортой ажиллагаа хариуцсан туслах: Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн Татварын улсын байцагч

Холбоо зарлан мэдээлэл хариуцсан туслах: Сүлжээний инженер

Сургалт, мэргэжлийн ангийн бэлэн байдал хариуцсан туслах: Бичил

татвар төлөгчтэй харилцах тасгийн Татварын улсын байцаагч

Хэв журам, эд хөрөнгө хамгаалах хариуцсан туслах: Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан туслах: Жижиг татвар төлөгчтэй

харилцах тасгийн Татварын улсын байцагч

Аж ахуй, хангалт хариуцсан туслах: Архив, бичиг хэрэг, нярав

2. Татварын хэлтсийн гамшгаас хамгаалах албаны орон тооны бус удирдлага штабын бүрэлдэхүүний ажил үүргийн хуваарийг нэгдүгээр, мэргэжлийн ангийн зохион байгуулалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Татварын хэлтсийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах, холбогдох судалгаа тооцоо гаргаж тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллахыг штабын дарга /Захиргаа, хуулийн тасгийн даргын албан үүргийг түр орон гүйцэтгэгч А.Ганчимэг/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ӨРДЭНЭСУВД



106181001